



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дугаар тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн, нийт 42,750,000.00 (дөчин хоёр сая долоон зуун тавин мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2."Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга Б.Гүрсоронзонд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захирамжийн актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл удирдлага зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4.Хөрөнгийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
133000343
5-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДЭСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн он/ Ашиглалтанд орсон он	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нийт балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Старекс, 0150ДГО, арлын дугаар: KMJWWN7HP2U469710	2002/2009	1	ш	2,000,000.00	1,500,000.00
2	Уаз 22069, 8480ТӨУ, арлын дугаар 374100D0413322	2013/2013	1	ш	4,500,000.00	3,000,000.00
3	Тоёота клугер, 0314УБҮ, арлын дугаар ACU200004727	2001/2010	1	ш	25,000,000.00	4,000,000.00
4	Метцубиши Делика, 3274УНЕ, арлын дугаар PD6W0702373	2002/2010	1	ш	2,250,000.00	1,800,000.00
5	Пургон, 1602ГАУ, арлын дугаар 374100D0413308	2013/2013	1	ш	4,500,000.00	2,000,000.00
6	Платз, 6758ГАУ, арлын дугаар SCP110031690	2000/2009	1	ш	4,500,000.00	1,000,000.00
Нийт дүн					42,750,000.00 (дөчин хоёр сая долоон зуун тавин мянга)	13,300,000.00 (арван гурван сая гурван зуу)